

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: БУА-2020/28/СТА-ТШЗ

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Бүрэгхангай сум 2020 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342729 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342729 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ

 БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580 <u>2020.01.29</u> № <u>15</u> Төвийн _____-ны № _____ Т Аудитын гэрчилгээ	БҮРЭГХАНГАЙ СУМЫНЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫНСУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ЭНХТУЯА ТАНАА
--	---

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

0000000

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.АНХБАЯР

2 Аудитын тайлан

2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Энхтуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр-наас 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газар-ын Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь Сургалтын болон сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэн сурлагын чанар сурагчдын авьяас чадварыг дээшлүүлж уламжлалт шинэчлэлтийг хослуулан хүүхдэд ээлтэй эрүүл чийрэг эерэг зан суртгуут хүмүүжил төлөвшилтэй амьдрах ухаантай эх оронч үндэсний бахархалтай иргэн болгож төлөвшүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага боловсрол
- Дунд боловсрол
- Бүрэн дунд боловсрол

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Засгийн газрын 106 дугаар тогтоол

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- Засгийн газрын оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын оны 24, 25 дугаар тогтоолууд
- Засгийн газрын оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай”
- Засгийн газрын оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Си ти эс” программ хангамж ашигладаг байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн хүрээнд зардлын ангиллаар зарцуулалт хийх, сургуулийн хувьд суурь үзүүлэлтийг сонгож ажиллах нь зүйтэй. -холбоотой юм.

2019 оны *Нийт зардал* 13,324.58 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 13,324.58 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь 2 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	453,560.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	453,560.00	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Акт, албан шаардлага, хариуцлага тооцох, хууль хяналтын байгууллагат шилжүүлсэн алдаа зөрчил гараагүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дотуур байр, үдийн цай хөтөлбөрийн хоолны норм нормативыг тогтоол шийдвэрийн дагуу олгож байгаа эсэх

Тайлангийн бичилт

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 823877.8 мянган төгрөг буюу 94 хувьтай байгаа нь Норм нормативын дагуу зарцуулаагүй шалтгаалжээ.

Төлөвлөгөө тасраагүй

2.11. Шилэн дансны мэдээлэл

Бүрэгхангай сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар Зөвлөмж өгөөгүй хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд үүссэн дотуур байрны хүүхдийн хоолны зардал 298.6, үдийн цай хөтөлбөрийн цайны зардал 154.9 мянган төгрөг илүү зарцуулсан байна.

Дотуур байрны хүүхэд болон үдийн цай хөтөлбөрийн хүнсний материалыг илүү олгосон нь Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1, 3 дугаар заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 2, 3 дугаар заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2018 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар зөвлөмж өгөөгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР

2020.01.29

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,265,535.15</u>	<u>46,213,203.15</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	37,265,535.15	46,213,203.15
354	Хангамжийн материал	37,265,535.15	46,213,203.15
35410	Бичиг хэргийн материал	1,325,800.00	1,291,800.00
35420	Аж ахуйн материал	23,910,745.15	32,281,283.15
35430	Сэлбэг хэрэгсэл	-	42,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	324,540.00
35450	Барилгын засварын материал	-	132,700.00
35460	Хүнсний материал	11,221,490.00	11,464,080.00
35470	Бусад хангамжийн материал	807,500.00	676,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>879,344,380.00</u>	<u>1,392,085,682.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	879,344,380.00	1,392,085,682.14
392	Биет хөрөнгө	879,344,380.00	1,335,913,864.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,162,397,412.00	1,232,074,992.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(389,343,343.60)	(1,120,097.97)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	96,244,516.91	93,671,810.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,639,922.35)	(42,105,343.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,700,252.96	74,662,465.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,538,612.72)	(29,075,491.14)
39217	Ном	7,524,076.80	7,805,526.80
393	Биет бус хөрөнгө	-	56,171,817.70
39303	Бусад биет бус хөрөнгө	-	56,171,817.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>916,609,915.15</u>	<u>1,438,298,885.29</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>916,609,915.15</u>	<u>1,438,298,885.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	916,609,915.15	1,438,298,885.29

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	237,517,804.44	269,517,804.44
51101	Өмч: - төрийн	237,517,804.44	269,517,804.44
512	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	142,853,512.05	155,734,763.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	(22,752,080.87)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	536,238,598.66	1,013,046,316.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>916,609,915.15</u>	<u>1,438,298,885.29</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	624,069,699.00	643,477,105.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	616,631,420.00	29,433,105.70
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,004,520.00	26,853,105.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,310,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,299,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,705,520.00	25,542,505.70
122	Тусламжийн орлого		
122001	Хандив тусламж /дотоод/	1,000,000.00	2,580,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	592,626,900.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,438,279.00	614,044,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	612,597,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,438,279.00	1,447,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	632,914,472.22	629,548,089.60

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	632,914,472.22	629,548,089.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	569,528,051.49	604,850,140.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,948,326.27	317,886,691.57
210101	Үндсэн цалин	201,230,526.27	230,335,962.57
210102	Нэмэгдэл	46,630,100.00	63,630,100.00
210104	Урамшуулал	23,278,200.00	23,920,629.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,809,500.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,316,100.00	37,313,176.01
210201	Тэтгэврийн даатгал	18,937,663.80	24,796,776.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,275,687.18	3,129,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,844,609.03	2,549,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	568,921.89	579,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,689,218.10	6,258,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,380,757.00	163,335,553.00
210301	Гэрэл, цахилгаан	4,432,687.00	6,115,313.00
210302	Түлш, халаалт	160,948,070.00	157,220,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,276,833.60	5,790,730.00
210401	Бичиг хэрэг	716,400.00	482,450.00
210402	Тээвэр, шатахуун	1,774,910.00	1,682,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,000.00	68,000.00
210404	Ном, хэвлэл	170,600.00	67,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	105,000.00	246,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,412,923.60	3,244,100.00
2105	Нормативт зардал	49,204,390.00	51,437,420.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	183,200.00	161,000.00
210502	Хоол, хүнс	49,021,190.00	51,276,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	741,300.00	403,650.00

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	741,300.00	403,650.00
2107	Томилолт, зочны зардал	196,000.00	112,000.00
210702	Дотоод албан томилолт	196,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	488,000.00	156,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	416,000.00	156,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,976,344.62	28,414,919.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,000.00	60,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,264,300.00	1,802,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,573,044.62	26,551,919.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,386,420.73	24,697,949.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,055,332.00	24,312,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,078,950.00	16,174,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,018,100.00	8,137,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,943,682.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,014,600.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,331,088.73	385,449.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,331,088.73	385,449.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(8,844,773.22)	13,929,016.10
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	655,561.60	36,681,096.97
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	655,561.60	36,681,096.97
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(655,561.60)	(36,681,096.97)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(9,500,334.82)	(22,752,080.87)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	613,567,079.00	615,354,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,299,000.00	1,310,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,299,000.00	1,310,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,299,000.00	1,310,600.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,310,600.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,299,000.00	-
122	Тусламжийн орлого	1,000,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	1,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	611,268,079.00	614,044,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	592,626,900.00	612,597,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	592,626,900.00	612,597,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,438,279.00	1,447,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,438,279.00	1,447,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,202,900.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	11,202,900.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	607,942,679.00	610,573,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	607,942,679.00	610,573,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	534,539,898.27	584,294,050.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,948,326.27	317,886,691.57
210101	Үндсэн цалин	201,230,526.27	230,978,391.57
210102	Нэмэгдэл	46,630,100.00	63,630,100.00
210104	Урамшуулал	23,278,200.00	23,278,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,809,500.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,316,100.00	37,313,176.01
210201	Тэтгэврийн даатгал	30,316,100.00	24,796,776.01
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,129,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,503,200.00

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	-	625,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,258,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,156,647.00	163,495,553.00
210301	Гэрэл, цахилгаан	4,432,687.00	6,115,313.00
210302	Түлш, халаалт	159,723,960.00	157,380,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,818,345.00	9,731,530.00
210401	Бичиг хэрэг	420,100.00	321,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,094,020.00	1,416,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,000.00	223,000.00
210404	Ном, хэвлэл	170,600.00	67,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	176,900.00	213,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,859,725.00	7,489,770.00
2105	Нормативт зардал	49,676,830.00	50,910,960.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,000.00	198,500.00
210502	Хоол, хүнс	48,608,830.00	49,831,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	870,000.00	880,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	312,000.00	514,000.00
210604	Урсгал засвар	312,000.00	514,000.00
2107	Томилолт, зочны зардал	168,000.00	112,000.00
210702	Дотоод албан томилолт	168,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	602,000.00	364,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,000.00	364,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,541,650.00	3,965,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	193,800.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,347,850.00	3,965,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,402,780.73	26,279,099.42

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	72,071,692.00	25,893,650.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	11,202,900.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,072,410.00	17,755,850.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,018,100.00	8,137,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,943,682.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,834,600.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,331,088.73	385,449.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,331,088.73	385,449.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,624,400.00</u>	<u>4,781,450.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,624,400.00	4,781,450.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,624,400.00	4,781,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,624,400.00	4,781,450.00
222001	Тоног төхөөрөмж	-	500,000.00
223001	Бусад хөрөнгө	5,624,400.00	4,281,450.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,624,400.00)</u>	<u>(4,781,450.00)</u>

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	237,517,804.44	536,238,598.66	152,353,846.87		926,110,249.97
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	237,517,804.44	536,238,598.66	152,353,846.87	-	926,110,249.97
C07	Тайлант үеийн үр дүн			(9,500,334.82)		(9,500,334.82)
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	237,517,804.44	536,238,598.66	142,853,512.05	-	916,609,915.15

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D0 1	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	237,517,804.4 4	536,238,598.66	142,853,512.05	-	916,609,915.15
D0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			35,633,332.77		35,633,332.77
D0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	237,517,804.4 4	536,238,598.66	178,486,844.82	-	952,243,247.92
D0 4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		476,807,718.24			476,807,718.24
D0 5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	32,000,000.00				32,000,000.00
D0 8	Тайлант үеийн үр дүн			(22,752,080.87)		(22,752,080.87)
D0 9	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,517,804.4 4	1,013,046,316.9 0	155,734,763.95	-	1,438,298,885.2 9

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	594624900.00	612236290.27	609597000.00	619586150.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594624900.00	606611890.27	609597000.00	614804700.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	532446400.00	534540198.27	583370200.00	588911050.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	275601900.00	274948626.27	312913000.00	317886691.57
210101	Үндсэн цалин	201884100.00	201230526.27	231004700.00	230978391.57
210102	Нэмэгдэл	46630100.00	46630100.00	58630100.00	63630100.00
210104	Урамшуулал	27087700.00	27088000.00	23278200.00	23278200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30316100.00	30316100.00	37549200.00	37313176.01
210201	Тэтгэврийн даатгал	19244300.00	19244300.00	25032900.00	24796776.01
210202	Тэтгэмжийн даатгал	2767800.00	2767800.00	3129100.00	3129100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2214200.00	2214200.00	2503200.00	2503200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	553600.00	553600.00	625800.00	625800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5536200.00	5536200.00	6258200.00	6258300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164795000.00	164156647.00	161695000.00	163495553.00
210301	Гэрэл, цахилгаан	3792100.00	4432687.00	3292100.00	6115313.00
210302	Түлш, халаалт	157092800.00	159723960.00	154492800.00	157380240.00
210303	Цэвэр, бохир ус	3910100.00		3910100.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	8581500.00	6818345.00	13918200.00	9722530.00
210401	Бичиг хэрэг	266000.00	420100.00	266000.00	312000.00

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	1424700.00	2094020.00	1424700.00	1416010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	710,600.00	97,000.00	710,600.00	223,000.00
210404	Ном, хэвлэл	236,100.00	170,600.00	236,100.00	67,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,800.00	176,900.00	214,500.00	213,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,718,300.00	3,859,725.00	11,066,300.00	7,489,770.00
2105	Нормативт зардал	49,688,000.00	49,676,830.00	54,175,600.00	50,910,960.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	198,500.00	198,000.00	198,500.00	198,500.00
210502	Хоол, хүнс	48,608,900.00	48,608,830.00	53,096,500.00	49,831,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	880,600.00	870,000.00	880,600.00	880,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	314,800.00	312,000.00	514,800.00	5,140,000.00
210604	Урсгал засвар	314,800.00	312,000.00	514,800.00	5,140,000.00
2107	Томилолт, зочны зардал	187,400.00	168,000.00	187,400.00	112,000.00
210702	Дотоод албан томилолт	187,400.00	168,000.00	187,400.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	602,000.00	602,000.00	602,000.00	364,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,000.00	530,000.00	530,000.00	364,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00	72,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,359,700.00	7,541,650.00	1,815,000.00	3,965,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,700.00	193,800.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,165,000.00	7,347,850.00	1,815,000.00	3,965,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,178,500.00	72,071,692.00	26,226,800.00	25,893,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,178,500.00	72,071,692.00	26,226,800.00	25,893,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,100,000.00	9,834,600.00	18,089,000.00	17,755,850.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,018,100.00	13,018,100.00	8,137,800.00	8,137,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,060,400.00	49,218,992.00		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,624,400.00	-	4,781,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,624,400.00	-	4,781,450.00
223001	Бусад хөрөнгө		5,624,400.00		4,781,450.00

«Audit_name» «Audit_year» оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	592,626,900.0 0	603,829,800.0 0	609,597,000.0 0	607,597,000.0 0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	592,626,900.0 0	592,626,900.0 0	607,597,000.0 0	607,597,000.0 0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	592,626,900.0 0	592,626,900.0 0	607,597,000.0 0	607,597,000.0 0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	11,202,900.00	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		11,202,900.00		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	2,000,000.00	-
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			2,000,000.00	